



**БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН  
ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛСАН ТАЙЛАН**



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### **Сэдэв:**

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нийтлэг зорилго
- Монгол улсад Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
- БНҮҮС-ын эх үүсвэр /харьцуулсан/
- БНҮҮС-ын бүтэц, зарцуулалт /харьцуулсан/
- Дүгнэлт



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

**1. Дэлхийн дахинд** бүх нийтийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сангуудын нийтлэг зорилго нь: Алслагдсан орон нутгийн хүн амд мэдээлэл, харилцаа холбооны хамгийн түгээмэл үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшинг үл хамааран алслагдсан хөдөө орон нутаг, хүн амд хүргэх боломжыг бүрдүүлэх, сүлжээг барьж байгуулахад оршино.

### **Нийтлэг зарчим:**

- Илүү хүртээмжтэй: аль ч цаг үед газарзүйн байрлалаас үл хамааран амьдарч буй орчиндоо харилцаа холбооны бүх үйлчилгээг авдаг байх
- Илүү боломжтой: үйлчилгээний үнэ нь түүний хүртээмжийг хязгаарладаггүй байх
- Илүү өргөн хүрээнд нэвтрэх: харилцаа холбооны үйлчилгээ нь тухайн орны нутаг дэвсгэрт арьс өнгө, хүйс, шашин шүтлэг гэх мэт ямар ч ялгаварлалгүйгээр үнэ, үйлчилгээний чанар адил тэгш байх боломжийг хангах



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

**2. Монгол улсын хувьд:** Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь 2001 онд “Харилцаа холбооны тухай” хуулийн хүрээнд анх үүсгэн байгуулагдсан. Монгол Улсын “Харилцаа холбооны тухай”, “Шуудангийн тухай”, Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн хүрээнд Засгийн газрын 2009 оны 151-р тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан /БНҮҮС/-г бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдээс албан татварт ногдох орлогын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөр эх үүсвэрээ бүрдүүлдэг.

**Сангийн зорилго:** Төрийн бодлогын хүрээнд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хамгийн түгээмэл үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшингөөс үл хамааран бодит үнээр хүргэх, алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх боломжыг бүрдүүлэх, сүлжээг шинээр барьж байгуулах, засварлах, өргөтгөх, үйлчилгээ явуулах зэргийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### 3. Дэлхийн улс орнуудын сангийн эх үүсвэр:

GSMA –ээс 2013 онд явуулсан дэлхийн улс орнуудын “Бүх нийтийн үйлчилгээний сангийн судалгаа”-нд нийт 64 улс хамрагдсан байна. Сангийн хөрөнгийн эх үүсвэрээр нь улс орнуудыг ялган дараах 6 төрөлд ангилан хүснэгт:1-т үзүүлэв.

- 1.Харилцаа холбооны чиглэлээр үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх ААН, байгууллагуудаас хууль журмын дагуу тодорхой хувийг санд төвлөрүүлэх
- 2.Үүрэн болон суурин холбооны үйлчилгээ үзүүлэгч оператор компаниудаас хууль журмын дагуу тодорхой хувийг санд төвлөрүүлэх
- 3.Үүрэн болон суурин холбооны үйлчилгээ үзүүлэгч оператор компаниудаас жил бүр тогтоосон хэмжээнээс илүү ашигтай ажилласан тохиолдолд ашгийн тодорхой хувийг /тогтмол дүнгээр/ санд төвлөрүүлэх
- 4.Тусгай зөвшөөрөл эзэмших эрхийн хураамж, түүний борлуулалт, торгууль, түүнийг эзэмших тендэр зэргээр олсон орлогыг санд төвлөрүүлэх
- 5.Улсын төсөвт тус сангийн хөрөнгийн хэмжээг жил бүр тодорхой хэмжээгээр тусгах
- 6.Бусад буюу дээрх 4 төрлөөс бусад бусад хэлбэрийн эх үүсвэрүүд



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### Хүснэгт 1: Дэлхийн улс орнуудын сангийн эх үүсвэр

Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх ААН		Үүрэн болон суурин бүх оператор		Үүрэн болон суурин бүх оператор-тогтмол дүн	Зөвшөөрөлийгн Хураамж, торгууль, төлбөр
<ul style="list-style-type: none"> <li>Tanzania-0.3%</li> <li>Romania-0,398%</li> <li>Bulgaria-0,8%</li> <li>Lesotho-1%</li> <li>Czech Republic-1%</li> <li>Uganda-1%</li> <li>Saudi Arabia-1%</li> <li>Bangladesh-1%</li> <li>Mozambique-1%</li> <li>Republic of South Africa-1%</li> <li>Indonesia-1.25%</li> <li>Rwanda-2%</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Sudan-2%</li> <li>Burkina Faso-2%</li> <li><b>Mongolia-2%</b></li> <li>Togo-2%</li> <li>Zimbabwe-2%</li> <li>Democratic Republic of Congo-2%</li> <li>Madagascar-2%</li> <li>Morocco-2%</li> <li>Sudan-2%</li> <li>Dominican Republic-2%</li> <li>Afghanistan-2.5%</li> <li>Thailand-4%</li> <li>India-5%</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Canada-0,84%</li> <li>Italy-1%</li> <li>Venezuela -1%</li> <li>Ecuador-1%</li> <li>Poland-1%</li> <li>Argentina-1%</li> <li>Brazil-1%</li> <li>Russian Federation-1,2%</li> <li>Pakistan-1,5%</li> <li>Cote d' Ivoire-2%</li> <li>Bolivia -2%</li> <li>Gabon-2%</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Nepal-2%</li> <li>Nicaragua -2%</li> <li>Ukraine-3%</li> <li>Niger-4%</li> <li>Nigeria-2.5%</li> <li>Mauritius-5%</li> <li>Vietnam-5%</li> <li>Colombia-5%</li> <li>Malaysia-6%</li> <li>Paraguay -20%</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Japan</li> <li>Korea (South)</li> <li>New Zealand</li> <li>France</li> <li>Hungary</li> <li>Swaziland</li> <li>USA</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Zambia</li> <li>Australia</li> <li>Oman</li> </ul>
				<b>Улсын төсөвт тусгагдсан</b>	<b>Бусад</b>
				<ul style="list-style-type: none"> <li>China</li> <li>Chile</li> <li>Guatemala</li> <li>Egypt</li> <li>Mexico</li> </ul>	Peru - 1% of all telecom CATV



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### **3. Дэлхийн улс орнуудын сангийн эх үүсвэр:**

GSMA–ээс 2013 онд явуулсан дэлхийн улс орнуудын “Бүх нийтийн үйлчилгээний сангийн судалгаа”-нд үндэслэн Харилцаа холбооны чиглэлээр үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх ААН, байгууллагуудаас хууль журмын дагуу тодорхой хувиас сангийн эх үүсвэрийг бүрдүүлдэг улс орнуудыг хүснэгт 2-т үзүүлэв. Тухайн улсын эдийн засаг, хүн ам, газар нутгийн хэмжээ зэргээс сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх хувь хэмжээ нь шууд хамааралтай байх бөгөөд үүнийгээ дагаад улс бүрт харилцан адилгүй байна.

Манай орны хувьд хүн ам харьцангуй маш бага, газар нутгийн хэмжээ том байгаа нь бусад улс орнуудтай харьцуулах боломжийг нэлээдгүй төвөгтэй болгож байна. Өмнөд Африк, Индонез зэрэг улсуудтай эдийн засаг, газар нутгийн хэмжээгээрээ ижил төстэй байгаа боловч хүн ам зүйн хувь харьцуулах боломжгүй эрс тэс нөхцөлтэй байгаа нь харагдаж байна.



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### Хүснэгт 2: Дэлхийн улс орнуудын хүн ам, газар нутаг, ДНБ харьцуулалт

Хөрөнгө төвлөрүүлэлтийн хувь /2013/	Нэг хүнд ноогдох ДНБ /2016/	Газар нутгийн хэмжээ	Хүн ам 2018 /сая/
<ul style="list-style-type: none"><li>Tanzania-0.3%</li><li>Romania-0,398%</li><li>Bulgaria-0,8%</li><li>Lesotho-1%</li><li>Czech Republic-1%</li><li>Uganda-1%</li><li>Saudi Arabia-1%</li><li>Bangladesh-1%</li><li>Mozambique-1%</li><li>South Africa-1%</li><li>Indonesia-1.25%</li><li>Rwanda-2%</li><li>Burkina Faso-2%</li><li><b>Mongolia-2%</b></li><li>Togo-2%</li><li>Zimbabwe-2%</li><li>Congo-2%</li><li>Madagascar-2%</li><li>Morocco-2%</li><li>Sudan-2%</li><li>Dominican Republic-2%</li><li>Afghanistan-2.5%</li><li>Thailand-4%</li><li>India-5%</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Tanzania - 1023\$</li><li>Romania - 9539\$</li><li>Bulgaria - 7496\$</li><li>Lesotho - 1217\$</li><li>Czech Republic - 18485\$</li><li>Uganda - 677\$</li><li>Saudi Arabia - 20318\$</li><li>Bangladesh - 1459\$</li><li>Mozambique - 379\$</li><li>South Africa - 5327\$</li><li>Indonesia - 3606\$</li><li>Rwanda - 735\$</li><li>Burkina Faso - 584\$</li><li><b>Mongolia - 3577\$</b></li><li>Togo - 590\$</li><li>Zimbabwe - 1383\$</li><li>Congo - 439\$</li><li>Madagascar - 400\$</li><li>Morocco - 2997\$</li><li>Sudan - 1403\$</li><li>Dominican Republic - 7189\$</li><li>Afghanistan - 561\$</li><li>Thailand - 6114\$</li><li>India - 1762\$</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Tanzania – 885.800km2</li><li>Romania – 230.080km2</li><li>Bulgaria – 108.560km2</li><li>Lesotho – 30.360km2</li><li>Czech Republic – 77.220km2</li><li>Uganda – 200.520km2</li><li>Saudi Arabia – 2.149.690km2</li><li>Bangladesh – 130.170km2</li><li>Mozambique – 786.380km2</li><li>South Africa – 1.213.090km2</li><li>Indonesia – 1.811.570km2</li><li>Rwanda – 24.670km2</li><li>Burkina Faso – 273.600km2</li><li><b>Mongolia – 1.553.560</b></li><li>Togo – 54.390km2</li><li>Zimbabwe – 386.850km2</li><li>Congo – 2.267.050km2</li><li>Madagascar – 581.800km2</li><li>Morocco – 446.300km2</li><li>Sudan – 1.886.000km2</li><li>Dominican Republic – 48.310km2</li><li>Afghanistan – 652.860km2</li><li>Thailand – 510.890km2</li><li>India – 2.973.190km2</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Tanzania – 56,3</li><li>Romania – 19,4</li><li>Bulgaria – 7,02</li><li>Lesotho – 2,1</li><li>Czech Republic – 10,6</li><li>Uganda – 42,7</li><li>Saudi Arabia – 33,7</li><li>Bangladesh – 161,3</li><li>Mozambique – 29,4</li><li>South Africa – 57,7</li><li>Indonesia – 267,6</li><li>Rwanda – 12,3</li><li>Burkina Faso – 19,7</li><li><b>Mongolia – 3,1</b></li><li>Togo – 7,8</li><li>Zimbabwe 14,4</li><li>Congo – 5,2</li><li>Madagascar – 26,2</li><li>Morocco – 36,0</li><li>Sudan – 41,8</li><li>Dominican Republic – 10,6</li><li>Afghanistan – 37,1</li><li>Thailand – 69,4</li><li>India – 1,352,6</li></ul>






# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### 4. БНҮҮС-ийн бүтэц, зарцуулалт:



Энэхүү графикаас харахад дэлхийн улс орнуудын сангийн хөрөнгө зарцуулалт нь Нигер, Афганистан, Прагвей зэрэг улсуудад маш муу, Энэтхэг, Бразил, Пакистан, Непал зэрэг улсуудад зарцуулалтын хувь хэмжээ харьцангуй муу, харин манай орны хувьд АНУ, Индонез, Венесуэл, Колумб зэрэг улсуудын адилаар сангийн хөрөнгийг үр ашигтай бүрэн зарцуулдаг улсуудын нэгээр шалгарсан байна.



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

**4. БНҮҮС-ийн бүтэц, зарцуулалт:** Дэлхийн улс орнуудын БНҮҮС-ийн бүтцийг түүний нэршлээр ангилан хүснэгт:3-т үзүүлэв. Үүнд дараах 5 төрөлд :ангилан үзүүлэв.

- Бүх Нийтийн Үйлчилгээний (Үүргийн) Сан /Universal Service (Obligation) Fund/
- Харилцаа Холбооны Сан /Telecommunication Fund/
- Харилцаа Холбооны Хөрөнгө Оруулалтын Сан /Investment Fund for Telecommunication/
- Мэдээллийн Дэмжих Сан /Information Support Fund/
- Харилцаа Холбооны Хөгжлийн Сан /Telecommunication Development Fund/

Сангийн нэршлээс хамааран сангийн хөрөнгийн эх үүсвэр болон түүнийг зарцуулах цар хүрээ нь харилцаа адилгүй байна. Хүснэгтэнд үзүүлсэнчлэн Бүх Нийтийн Үйлчилгээний Үүргийн Сан гэх нэршил, бүтэц, зохион байгуулалт нь олон улсад хамгийн түгээмэл байдаг. Манай орны Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн бүтэц зохион байгуулалтыг график:2-т үзүүллээ.



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### Хүснэгт 3: БНҮҮС-ийн бүтэц, зарцуулалт

#### Бүх Нийтийн Үйлчилгээний Сан /Universal Service Fund/

Burkina Faso, Gabon, Lesotho, Mauritius, Morocco, Mozambique, Nigeria, Republic of South Africa, Rwanda, Swaziland, Tanzania, Zambia, Zimbabwe, Australia, Bangladesh, India, Indonesia, Japan, Mongolia, New Zealand, Pakistan, Philippines, Thailand, Bulgaria, Czech Republic, France, Italy, Poland, Romania, Russian Federation, Argentina, Brazil, Paraguay, Venezuela, Egypt, Saudi Arabia, USA

#### Харилцаа Холбооны Сан /Telecommunication Fund/

Cote d' Ivoire, Democratic Republic of Congo, Malaysia, Vietnam, Guatemala, Mexico

#### Харилцаа Холбооны Хөрөнгө Оруулалтын Сан

/Investment Fund for Telecommunication/

Ghana, Madagascar, Uganda,, Colombia, Peru,

#### Мэдээллийн Дэмжих Сан /Information Support Fund/

Sudan, Hungary

#### Харилцаа Холбооны Хөгжлийн Сан /Telecommunication Development Fund/


Nepal, Afghanistan, South Korea, Chile



# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

График 2: БНҮҮС-ийн бүтэц





# БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

## Олон улсын харьцуулсан судалгаа

### Дүгнэлт:

- Бүх нийтийн үйлчилгээний сан нь Харилцааны холбооны үйлчилгээг алслагдсан хөдөө орон нутагт адил тэгш түгээх боломжийг бүрдүүлдэг дэлхий дахинаа хамгийн түгээмэл тархсан бүтэц зохион байгуулалттай сан юм.
- Дэлхийн ихэнх улс орнууд нь сангийн эх үүсвэрийг энэ Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүдээсээ бүрдүүлдэг байна.
- Дэлхийн банк болон GSMA-ын судалгаанаас харахад “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”-ийн үйл ажиллагаа, зохион байгуулалт болон хөрөнгө зарцуулалтын хувьд дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад манай улс харьцангуй сайн байдаг.
- Дэлхийн улс орнууд харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан хөдөө орон нутагт хүргэх, дижитал хуваагдалыг багасгахад БНҮҮС-ийн үйл ажиллагааг чухал ач холбогдолтой гэж үзжээ.